

ГАРЧИГ

- 2–4 Бодлогын нийтлэл
- 5–7 Зохицуулалтын мэдээ
- 8–9 Байр суурь
- 10–11 Хөрөнгийн зах зээлийн ногоон бүтээгдэхүүн
- 12–13 Регтек ба өнөөгийн нөхцөл байдал
- 14–21 Судлаачийн индэр
- 22–23 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн мэдээллийн ил тод байдал
- 24–25 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэж юу вэ?
- 26–27 Олон улсын зах зээлийн мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨЖ БОЛОХ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙД ТООЦОГДДОГ



Гадаад валютын арилжаа эрхлэгч банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой зарим асуудлын талаар Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Ахлах зөвлөх А.Баянмөнхтэй ярилцлаа.

Ярилцлагаа банк бус санхүүгийн байгууллагуудын эрхэлж буй валютын арилжааг төрөөс анх хэрхэн зохицуулж эхэлсэн талаар яриагаар эхлүүлье.

Энэ асуултад нэгдүгээрт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хүрээнд, хоёрдугаарт, иргэд, олон нийтийн нэршиж дадсанаар валют солих цэгээр дамжуулан өөрөөр хэлбэл, Найман шарга төв, түүний эргэн тойронд үйл ажиллагаа эрхэлдэг валютын солилцоо, арилжаа эрхлэгчдийн хувьд тухайлан тайлбарлах нь зүйтэй байх.

Төр засгийн зүгээс үндэсний валют болох төгрөгийн худалдан авах чадварыг хадгалах, үнэгүйдлээс хамгаалж, ханшийг тогтвортой байлгахад чиглэгдсэн тодорхой арга хэмжээг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тухайн цаг хугацаанд авч хэрэгжүүлсээр ирсэн. Эдгээр арга хэмжээний нэг нь 1994 онд баталсан, өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Валютын зохицуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хүрээнд Улсын Их Хурлын мөн оны 37 дугаар тогтоолоор зочид буудал, нисэх онгоцны болон галт тэрэгний буудал зэрэг байгууллагад гадаад бэлэн валютаар ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг хянан олгох, валют худалдан авах, худалдах үйлчилгээг банкаар дамжуулан гүйцэтгүүлэх бэлтгэлийг хангах ажлыг хэрэгжүүлэхийг Монголбанканд даалгасан байдаг. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкны ерөнхийлөгчийн 1995 оны 165 дугаар тушаалаар “Валют худалдан авах, худалдах цэгийн дүрэм”-ийг баталж, Монголбанкнаас валют солих цэг (цаашид “ВСЦ” гэх)-ийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг анх олгож, хяналтыг тавьж эхэлсэн түүхтэй. Үүнээс хойш ВСЦ-ийн хяналт, зохицуулалт Санхүүгийн зохицуулах хороонд шилжих хүртэл хугацаанд уг чиг үүргийг Монголбанк хэрэгжүүлсээр ирсэн.

Банк бус санхүүгийн байгууллага (цаашид “ББСБ” гэх)-ын тухайд 2002 оны 12 дугаар сард батлагдан, 2003 оны 02 дугаар сараас мөрдөгдөж эхэлсэн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулиар гадаад валютын арилжааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх боломжтой болсон. Ингэхдээ төрийн бодлого, зохицуулалтын хүрээнд ВСЦ-үүдийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зохицуулалтад хамааруулан тусгай зөвшөөрөл олгож эхлэх хүртэл хугацаанд ББСБ-ууд нь гадаад валютын валютын арилжааг нэмэлт тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байсан онцлогтой.


Үргэлжлэлийг 8-р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ

Төсвийн зарлага, орлогын хариуцлагыг төв засгийн газраас орон нутгийн захиргаатад шилжүүлэх. Төвлөрөл хэр саарсныг орон нутгийн захиргааны төв засгийн газраас хараат бус байдал хэр зэрэг дээшилснээр хэмждэг.



FISCAL DECENTRALIZATION

Fiscal decentralization involves transferring expenditure and revenue responsibilities from the central government to subnational governments. The degree of decentralization (whether fiscal or administrative) can be measured by the extent of autonomy of the subnational entities from the central government.

Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

Даатгалын компаниудын нийт хөрөнгө 2022 оны жилийн эцсийн байдлаар 474.8 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 11.6 хувиар өссөн байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувийг даатгагчийн төрлөөр авч үзвэл, ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 398.2 тэрбум төгрөг буюу нийт даатгагчдын хөрөнгийн 83.9 хувийг, урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгө 16.3 тэрбум төгрөг буюу нийт даатгагчдын хөрөнгийн 3.4 хувийг, давхар даатгалын компанийн хөрөнгө 60.3 тэрбум төгрөг буюу нийт даатгагчдын хөрөнгийн 12.7 хувийг тус тус эзэлж байна. Мөн даатгалын болон давхар даатгалын нийт хураамжийн орлого 304.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс ердийн даатгалын нийт хураамжийн орлого 297.9 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын нийт хураамжийн орлого 2.7 тэрбум төгрөг, давхар даатгалын хураамжийн орлого 4.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт 94.4 тэрбум төгрөгийг даатгалын нөхөн төлбөрт олгосон нь өмнөх оноос 36.8 хувиар өссөн байна.

Манай улсын даатгалын гүнзгийрэлтийн түвшин буюу даатгалын хураамжийн нийт орлого ДНБ-ний харьцаа 0.63 хувь, даатгалын нягтрал буюу нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого нь 87.8 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй

байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын салбарын эрх зүйн орчныг шинэчлэх, олон нийтэд даатгалын боловсрол олгох, даатгалын мэдлэгийг дээшлүүлэх, даатгалын зах зээлд оролцогч, зохицуулалттай этгээдүүд болон мэргэжлийн холбоодын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, чадавхжуулах, олон улсын стандарт, зарчмыг нэвтрүүлэх, тогтвортой санхүүжилтийг дэмжих ажлын хүрээнд дараах бодлого, зохицуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүллээ:



Даатгалын багц хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд:

Даатгалын багц хууль буюу Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Хорооны болон Сангийн яамны цахим хуудсанд байршуулж, иргэд олон нийт болон даатгалын мэргэжлийн холбоод, салбарын оролцогчдоос тус тус холбогдох саналыг авч ажилласан. Хуулийн төсөлд ирүүлсэн саналтай холбоотойгоор 2022 оны 7, 8, 9 дүгээр саруудад даатгалын мэргэжлийн холбоод, даатгалын компаниуд болон холбогдох төрийн байгууллагуудтай 20

гаруй уулзалт хийснээс гадна нэгдсэн хэлэлцүүлгийг 11 дүгээр сард зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнд хуулийн төслийн эцсийн хувилбарыг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд Сангийн яамны зүгээс Засгийн газрын хуралдаанд танилцуулж, УИХ-д өргөн барихаар ажиллаж байна.



Даатгагч баталгаа гаргах үйл ажиллагааны зохицуулалтын орчныг бий болгох хүрээнд:

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Даатгалын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан. Эдгээр хуулиудын хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 46 дугаар тогтоолоор “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг баталсан бөгөөд уг журмаар даатгалын компани баталгаа гаргах тохиолдолд санхүү, төлбөрийн чадвар болоод удирдлага, зохион байгуулалтын хувьд ямар шаардлага тавигдах, хэдий хэмжээний баталгааг гаргаж болох, үүсч болзошгүй эрсдэлээс хэрхэн сэргийлэх зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан. Ийнхүү даатгалын компаниудын баталгаа гаргах хууль эрх зүйн орчин бүрэн бүрдсэн.

Тэгвэл, даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэхтэй холбоотой даатгалын компаниуд нэгдэн 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хамтын ажиллагааны гэрээг байгуулан, хамтын удирдлагын бүтцийг байгуулсан байна. Тус хамтын удирдлагын бүтцээс даатгагчийн баталгааны үйл ажиллагааны журам, баталгааны гэрээний төсөл, баталгаа гаргуулах хүсэлтийн маягт, баталгааны хураамжийн тооцоолол зэргийг боловсруулаад байгаа бөгөөд даатгалын компаниуд нийт 50.0 орчим тэрбум төгрөгийн баталгааг гаргах боломжтой байна.

Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаа нь салбарын эрэлт, нийлүүлэлтийг өсгөж, салбарын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлага, санхүүгийн чадамжийг дээшлүүлэх, санхүүгийн салбарт зөв өрсөлдөөнийг бий болгох, мөнгөн урсгалын эргэлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.



“Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцааны журам”, “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ын талаар:

Даатгагчийн эрсдэлийг илүү бодитой, нарийвчилсан, өөрт тохирсон аргаар тооцоолох боломжийг олгох, даатгагчийн төлбөрийн чадварыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн сайжруулж эрсдэлд суурилсан аргачлалаар тооцох зорилгоор тогтмол хувь, хязгаарлалт, дүрэмд суурилсан аргачлалаас эрсдэлд суурилсан аргачлалд шилжих шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан “Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцааны журам”, “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ыг Хорооны 2022 оны 558 дугаар тогтоолоор баталсан. Журам, зааврыг хэрэгжүүлж эхэлснээр даатгагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нээлттэй, ил тод, боловсронгуй болж, даатгалын зах зээлийн эрсдэлийг урьдчилан таних, түүнээс сэргийлэх систем нэвтрэх, улмаар салбарын тогтвортой байдал хангагдаж, хөрөнгө оруулагч, даатгуулагчдын даатгалд итгэх итгэл нэмэгдэн, салбарын нэр хүнд өсч, зах зээл өргөжин тэлэх чухал ач холбогдолтой юм.

Журмын зарим зохицуулалт нь 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжих бөгөөд Хорооны зүгээс журам батлагдсантай холбогдуулан төлбөрийн чадварын холбогдох маягт тайлангуудыг шинэчлэн боловсруулах, даатгалын байгууллагуудаас тайлан хүлээн авах ажлуудыг хэрэгжүүлэх, цаашлаад тайлантай холбоотой болон журмын бусад зохицуулалтыг сайжруулах хүрээнд даатгалын компаниудтай хамтран ажиллаж байна.



Олон нийтэд даатгалын боловсрол олгох, даатгалын мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд:

Иргэдийн эрсдэл, даатгалын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, даатгалын зах зээлд итгэх итгэлийг бий болгох нь даатгалын ач тусыг хүртэх, даатгалыг эрсдэлд өртөмтгий байдлыг бууруулах болон ядуурлаас хамгаалах амьдралын чухал хэрэглээ болгон ашиглах боломжийг нэмэгдүүлэх юм. Үүнийг олон нийтэд даатгалын боловсрол олгох хөтөлбөрөөр дамжуулан хүргэх боломжтой.

Тухайлбал, Япон улсад хүн амын насны онцлогт тохируулсан санхүүгийн боловсрол олгох 8 бүлэгтэй стандарт хөтөлбөрийн

1 бүлэгт нь даатгалын боловсрол олгохоор нарийвчлан тусгажээ. Энэхүү стандарт хөтөлбөр нь сургуулийн боловсролын хөтөлбөрт тусгагдсан бөгөөд хүүхдийг бага наснаас нь эхлэн эрсдэлийг таниулах, даатгалын ач тусыг ойлгуулахаас гадна их сургуулийн оюутнууд, насанд хүрэгчдийн насны онцлог, хэрэгцээнд нь суурилсан цогц хөтөлбөрийг нэвтрүүлсэн сайн туршлага байна.

Иймд олон нийтийн санхүүгийн боловсролын чухал бүрэлдэхүүн хэсгийн нэг болох даатгалын боловсролыг дээшлүүлэхийн тулд үндэсний хэмжээний суурь судалгаа хийж, судалгаанд үндэслэн олон улсын сайн туршлагуудтай уялдсан хөтөлбөр боловсруулан олон нийтийн санхүүгийн боловсролын урт хугацааны хөтөлбөрт тусгах ажлыг удирдан зохион байгуулах үүрэгтэй ажлын хэсгийг Хорооны даргын 2023 оны 3 дугаар сарын 31–ний өдрийн 188 тоот, даатгалын талаар олон нийтэд зөв ойлголт өгөх, мэдлэг, мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулах үүрэгтэй ажлын хэсгийг Хорооны даргын 2023 оны 3 дугаар сарын 31–ний өдрийн 187 тоот тушаалаар тус тус байгуулан шаардлагатай ажлуудыг хамтран хэрэгжүүлж эхлээд байна.



Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн хариуцлагын даатгалын хүрээнд:

УИХ–ын гишүүн Ж.Чинбүрэнгийн санаачилгаар эрүүл мэндийн салбарынхан, даатгалын салбарынхан болон холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоодыг хамруулсан “Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн даатгалын хэрэгцээ, шаардлага” сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 6 дугаар сарын 03–ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгээс гарсан саналыг эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч, сувилагч, ажилтнуудаар нээлттэй хэлэлцүүлж, шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Засгийн газарт өргөн мэдүүлэх нь зүйтэй талаар шийдвэрлэсний дагуу Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 17–ны өдрийн А/96 тоот тушаалаар “Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгал, эмч, ажилтнуудыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний эрсдэлийн

даатгалд хамруулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулагдсан. Уг ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл орж, ажиллаж байгаа бөгөөд эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлох, үүнтэй холбогдох зохицуулалтыг Даатгалын тухай болон Эрүүл мэндийн тухай хуульд оруулах саналыг боловсруулахаар ажиллаж байна. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс энэхүү даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалтыг сайжруулах зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн хариуцлагын даатгалын талаар судалж, санал боловсруулах дэд ажлын хэсгийг даатгалын компаниудын төлөөллөөс бүрдүүлэн хамтран ажиллаж байна.



Малын индексжүүлсэн даатгалын зохицуулалтын хүрээнд:

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2–т заасан давхар даатгалын компанийн дунд болон дээд түвшний эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулахтай холбоотой харилцааг зохицуулахаар Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 07–ны өдрийн 107/53 тоот хамтарсан тушаалаар “Давхар даатгалын компанийн эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам”–ыг баталлаа.

Энэхүү журам батлагдсанаар давхар даатгалын компанийн дунд болон дээд түвшний эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын удирдлагыг зөв зохистой оновчтой хэлбэрээр хэрэгжүүлэх, сангийн хөрөнгийг олон талт хөрөнгө оруулалтад байршуулж, эрсдэлийг тархаан байршуулахад чухал ач холбогдолтой юм.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ЯВУУЛАХ ЧИГЛЭЛД СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн болон санхүүгийн бус салбарын оролцогчдыг зохицуулах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд зохицуулалттай салбаруудын оролцогчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх, тэдгээрийн мэдлэг, мэдээллийг сайжруулах, салбарын өсөлтийг дэмжих зорилгоор мэргэжлийн холбоодтой байнга хамтран ажиллаж мөн холбогдох сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг. Тодруулбал, мэргэжлийн 14 холбоотой хамтран 20 гаруй сургалтыг зохион байгуулж байна. Эдгээр сургалтын чанар, стандартыг сайжруулах, сургалтын хүртээмж, үр дүнг нэмэгдүүлэх буюу салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалтыг үр дүнтэй явуулах зорилгоор “Сургагч багш бэлтгэх” сургалтыг зохион байгууллаа.

“Санхүүгийн боловсролын зангилаа” ГҮТББ-тай хамтран зохион байгуулсан сургалтад Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох 20 албан хаагч хамрагдаж мэргэшүүлэх сургалтуудын чанар, үр дүнг сайжруулах чиглэлд мэдлэг, мэдээлэл олж авлаа. Тус албан хаагчдад дээрх төрийн бус байгууллагын туршлагатай зөвлөх багш нар “Насанд хүрэгчид”-ийн сургалтын хэрэгцээнд тулгуурлан сургалтын зорилго, үр дүнг оновчтой тодорхойлох, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг үр дүнтэй төлөвлөх, цахим болон танхимын сургалтын арга хэрэгслийг хэрхэн ашиглах мөн сургалтыг хэрхэн үнэлэх зэрэг ур чадварын талаар сургалт мэдээлэл өгсөн юм.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН БҮТЭЭЛҮҮДИЙГ ОЛОН НИЙТЭД ДЭЛГЭЛЭЭ



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг дэмжих, бүтээгдэхүүн, үйлчилгээг нь олон нийтэд таниулан сурталчлах зорилготой “Mongolian jewellery and metal expo” үзэсгэлэн “Мишээл экспо” олон улсын худалдааны танхимд өнөөдөр нээлтээ хийлээ.



Санхүүгийн зохицуулах хороо, Соёлын яам, Монголбанк, Стандарт, хэмжил зүйн газар болон холбогдох бусад байгууллагаас хамтран хоёр дахь жилдээ зохион байгуулж буй энэ удаагийн үзэсгэлэнг нээж Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хороо нь 2020 оноос санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид болох үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарыг зохицуулж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэлжүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсны үр дүнд

өнөөдрийн байдлаар 47 хуулийн этгээд, 465 иргэн тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаагаа эрхэлж байна. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбар нь салбар дундын зохицуулалттай тул алсыг харсан, олон улсын жишиг, сайн туршлага, судалгаа шинжилгээнд тулгуурласан хөгжлийн бодлогыг тодорхойлж, бизнес, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахад оролцогч байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаа, арилжаа эрхлэгчдийн идэвх нэн чухал ач холбогдолтой” гэдгийг онцолсон юм.

Үзэсгэлэнгийн үеэр Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллага үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд салбарын талаарх цаг үеийн холбогдох мэдээлэл, танилцуулга, сургалтыг зохион байгууллаа.

ХҮРТЭЭМЖТЭЙ НОГООН САНХҮҮЖИЛТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛНЭ



Олон улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-ээс зохион байгуулж буй “Төр, хувийн хэвшлийн хэлэлцүүлэг”-т Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан оролцож байна. АНУ-ын Вашингтон хотноо болж буй энэ удаагийн хэлэлцүүлэг “Ногоон санхүүжилтийг өргөжүүлэх чиглэлд төр, хувийн хэвшлийн түншлэл” сэдвийн хүрээнд болж буй бөгөөд Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн хаврын чуулга уулзалттай хамт болж байгаагаараа онцлогтой юм.

Сүүлийн жилүүдэд улс орон бүр цаг уурын өөрчлөлтийг бууруулах зорилгоор ногоон санхүүжилтийг дэмжих чиглэлд ихээхэн анхаарах болсон. Тухайлбал, тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх үзэл баримтлалыг

үндэсний хөгжлийн стратегидаа тусгах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн эрсдэлийн удирдлага, мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлэх, ногоон таксаноми зэрэг зохицуулалтын арга хэрэгслийг Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн гишүүн орнууд амжилттай нэвтрүүлэх болсон. Гэхдээ цаг уурын өөрчлөлттэй холбоотой эрсдэл улс орон бүрт харилцан адилгүй, тэр дундаа хөгжиж буй орнуудад тулгарч буй уур амьсгалын доройтлыг багасгах зохицуулалтын арга хэрэгслүүд хангалтгүй төвшинд байгаа билээ. Иймээс хэлэлцүүлгээр хүртээмжтэй ногоон санхүүжилтийн бодлого, зохицуулалтыг гишүүн орон бүрт эрчимжүүлэх тэр дундаа ногоон санхүүжилтийг хөгжүүлэх бодлогын арга хэмжээнд хувийн хэвшлийн санаачилгыг тусгах, тодруулбал төр, хувийн хэвшлийн түншлэлийг энэ чиглэлд өргөжүүлэх буюу хамтын ажиллагааг илүүтэй хөгжүүлэх чиглэлд хамтарч ажиллахаар санал нэгдлээ.

Олон улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг нь 89 орны 100 гаруй санхүүгийн болон зохицуулагч байгууллагын гишүүнчлэлээс бүрдсэн дэлхийн санхүүгийн хүртээмжийн бодлого тодорхойлогч, олон улсын бичил санхүүгийн зах зээлийн 85 хувийг хамарсан, хүн амын ядуу буурай хэсэгт санхүүгийн үйлчилгээг ойртуулах чиглэлээр ажилладаг олон улсын байгууллага юм. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан нийгэмлэгийн Зүүн Европ Төв Азийн бүсийн зөвлөлийг 2021 оны зургаадугаар сараас хойш даргалж байна.

ХААН БАНК ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГАА ЭХЛҮҮЛЛЭЭ



“ХААН банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх цан цохих ёслол боллоо. Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Н.Хүдэрчулуун, Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч Г.Дөлгөөн, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх

захирал Х.Алтай, “ХААН банк” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Т.Дарьбум, гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа болон холбогдох



бусад хүмүүс оролцлоо. Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “УИХ, Засгийн газраас хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, түүний эдийн засагт гүйцэтгэх үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ банкны салбарын реформын хүрээнд системд нөлөө бүхий банкуудыг хөрөнгийн зах зээл дээр гаргаж, нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, төрийн өмчит компаниудыг хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгож, үр ашиг, засаглалыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байгааг хэлэхэд таатай байна. Тэр дундаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, дотоодын компаниудыг хөрөнгийн зах зээлээр дамжуулан урт хугацааны санхүүжилт татах хөшүүргийг бий болгох үүднээс хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчинг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, дэд бүтцийн шинэчлэл буюу үнэт цаасны дараа төлбөр тооцооны горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг нэвтрүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллалаа. “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах” арга хэмжээний хүрээнд дэд бүтцийн байгууллагуудын үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны шимтгэл хураамжийг бууруулсны зэрэгцээ үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдыг бодлогоор дэмжих үүднээс татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, санаачилга гарган ажиллаж, үүний үр дүнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нийтэд санал болгон нээлттэй арилжаалагдах үнэт цаас гаргасан тохиолдолд үнэт цаас гаргахтай холбоотой гарсан зардлыг

20 хувиар нэмэгдүүлж албан татвар ногдох орлогоос хасаж тооцох, хөрөнгө оруулалтын сангийн орлогыг татвараас чөлөөлөх, нээлттэй компаниудын ногдол ашгийн татварыг 50 хувиар бууруулах зохицуулалтууд орж, энэ оноос мөрдөж эхэллээ.

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИДТОЙ ХАМТАРСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Биржийн бус зах зээлийн хяналт, зохицуулалт, өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар зах зээлийн оролцогчидтой нээлттэй хэлэлцэх, талуудын оролцоог хангасан хамтын ажиллагааны хүрээнд цаашид хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг оновчтой тодорхойлох зорилгоор өнгөрсөн лхагва гарагт зохион байгуулсан хэлэлцүүлэгт Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо (МУЦАЭХ), тус зах зээлд оролцогч андеррайтерийн компаниудын удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд оролцлоо.

Хэлэлцүүлгийг нээж Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал хэлсэн үгэндээ “Хорооны 2020 оны 995 дугаар тогтоолоор баталсан “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-аар МУЦАЭХ нь биржийн бус зах зээлийг удирдан зохион байгуулах чиг үүрэг хүлээсэн. Тус зах зээлийн үйл ажиллагаа албан ёсоор эхэлсэн 2021 оны есдүгээр сараас хойших хугацаанд нийт 74 компанийн 1.53 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 94 өрийн хэрэгсэл гарсан бөгөөд 1.02 их наяд төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн байна. Харин энэ оны нэгдүгээр улиралд 16 үнэт цаас гаргагчийн 109.55 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, 42 транч хэрэгслийг бүртгэж, 62.55 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Өнөөдрийн байдлаар биржийн бус зах зээлийн шууд оролцогч болох үнэт цаасны 29 компани, шууд бус оролцогч 2126 этгээд байгаа бөгөөд нийт 2,155 оролцогч байна” гэдгийг онцлон дурдсан юм.

БАЙР СУУРЬ

ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨЖ БОЛОХ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙД ТООЦОГДДОГ

Гадаад валютын арилжаа эрхлэгч банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой зарим асуудлын талаар Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Ахлах зөвлөх А.Баянмөнхтэй ярилцлаа.

Эхлэл нь 1-р нүүрт



ВСЦ-ийн хяналт, зохицуулалтыг өмнө нь Монголбанк хариуцаж байсан талаар та дурдсан. Тэгэхээр хэдэн оноос эхлэн Санхүүгийн зохицуулах хороо ВСЦ-ийн хяналт, зохицуулалтыг хариуцах болов, өнөөдрийг хүртэлх хугацаанд зохицуулалтын чиглэлээр ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллав?

Энэ процесс 2006 оноос эхлэлтэй. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль 2005 оны 11 дүгээр сард батлагдсанаар 2006 оны 1 дүгээр улирлаас банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянах байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороо үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлж байсан. Үүнтэй холбоотойгоор Монголбанк, Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 11 дүгээр сард байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т ВСЦ-ийн зөвшөөрөл олгох, нөхцөл, шаардлагыг тогтоох, хяналт тавих зэрэг зохицуулалтыг манай байгууллагын зохицуулалтын хүрээнд хамруулахаар тусгаж, улмаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2007 оны 5 дугаар сарын хуралдаанаар

холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулан, үйл ажиллагааны талаарх зохицуулалт тодорхой болох хүртэл хугацаанд тус цэгийн хяналт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зөвлөмжийг гаргаснаар Санхүүгийн зохицуулах хороо мөн оны 12 дугаар сард “Валют солих цэгийн түр журам”-ыг батлан өмнө нь Монголбанкнаас зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байсан 52 иргэн, хуулийн этгээдээс 13-т нь зөвшөөрлийг шинэчлэн олгож, 39 этгээдийн зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэрийг анх гаргаснаар зохицуулалтын арга хэмжээг авч эхэлсэн.

ВСЦ-үүдийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зохицуулалтад хамруулах болсон үндэслэл, шалтгаан юу байв?

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2007 оны зөвлөмжийг үндэслэл болгон 2009 онд ВСЦ-ийн зөвшөөрөлтэй байсан 32 хуулийн этгээдийн зөвшөөрлийг хүчингүй болгож, эдгээрээс хүсэлтээ ирүүлж, холбогдох нөхцөл шаардлагыг хангасан 28 хуулийн этгээдэд гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосноор ВСЦ-үүдийн үйл ажиллагааг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зохицуулалтад анх оруулж эхэлсэн. Тухайн үедээ ийнхүү шийдвэрлэх болсон хэд хэдэн шалтгаан бий. Хамгийн гол бодит шалтгааны нэг нь ВСЦ-үүдийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан зохицуулалт бүхий хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байсантай шууд холбоотой. Үүнийг дагаад тайлагнал, зах зээл дээр эргэлдэж буй хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн гарал үүсэл, техник тоног төхөөрөмжийн баталгаат байдал, ажлын байрны аюулгүй байдал, иргэд-үйлчлүүлэгчдийн эрх ашиг, залилан, луйвар болон мөнгө угаах гэмт хэрэг зэрэг олон

асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлох, зохицуулах, хянан шийдвэрлэх, хариуцлага ногдуулахад ойлгомжгүй байдлыг үүсгэж байсан.

Тэгвэл хуулийн зохицуулалтад хамруулснаар ямар үр дүнд хүрсэн бэ?

Үр дүнгийн хувьд нарийвчилсан хуулийн зохицуулалтад орсноор сая миний дурдсан асуудлуудыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломж бүрдсэн. Товчхондоо, ВСЦ-үүд нь Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэгч буюу мэргэжлийн санхүүгийн зуучлагч байгууллага-хуулийн этгээд болох эхлэлийг тавьсан. Нэг зүйлийг онцлон хэлэхэд иргэд гар дээрээс валютын дураараа сольдог, арилждаг байдлыг таслан зогсоох зорилгоор бид Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тодорхой саналыг 2013 оны 12 дугаар сард Эдийн Засгийн Байнгын Хороонд хүргүүлсэн нь дэмжигдэн, Улсын Их Хурлын 2014 оны 01 дүгээр сарын хуралдаанаар батлагдсанаар иргэд гадаад валютын худалдаа эрхлэх эрх зүйн үндэслэлгүй болж байсан нь бодлого, зохицуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний томоохон үр дүнгийн нэг гэж ойлгож болно.

Та бид хоёрын яриа өмнө нь ВСЦ нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан, одоо Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд гол төлөв гадаад валютын арилжааг дагнан буюу дангаар эрхэлдэг ББСБ болсон шилжилтийн үеийн зохицуулалтын тал дээр нэлээд түлхүү төвлөрлөө. Энэхүү сэдвийн хүрээнд ойрын хугацаанд хяналт шалгалт, зохицуулалтын чиглэлээр ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар товчхон мэдээлэл өгөөч.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (цаашид “ФАТФ” гэх)-аас гаргасан санхүүгийн үйлчилгээний талаарх тодорхойлолтоор харилцагчийн нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлэгчдийн нэг болох мөнгө, гадаад валют солих

үйлчилгээ эрхлэгч нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй. ФАТФ-ын жил тутмын судалгаанд үндэслэн гаргасан тайлангаар гадаад валютын арилжааны үйл ажиллагаа нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөж болох өндөр эрсдэлтэйд тооцогддог учраас уг үйл ажиллагаа эрхлэгч нь тусгай зөвшөөрөл, бүртгэлтэйгээр үйл ажиллагаа эрхлэх шаардлагыг тавьдаг, нэгдүгээрт. Хоёрдугаарт, ялангуяа нийслэл дэх Найман шарга гэх мэт зарим байршлуудад тусгай зөвшөөрөлгүйгээр, гар дээрээс валют солих, арилжаа хийх тохиолдлууд гарсаар байгаа нь зөвшөөрөлгүй, хууль бус үйл ажиллагаа эрхэлж этгээдийн хувьд ч, тэдгээрээс үйлчилгээ авч байгаа иргэдийн хувьд ч миний өмнө дурдсан эрсдэлүүд байсаар байна. Өнөөдрийн байдлаар энэ чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс сарын аян зарлан тусгай зөвшөөрөлтэйгөөр гадаад валютын арилжаа эрхлэгч санхүүгийн зуучлагч байгууллагууд болон банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэгч иргэд, олон нийтэд чиглэсэн валютын мэдээ, мэдээллийг төрөл бүрийн хэлбэрээр мэдээллийн боломжит сувгуудыг ашиглан хүртээмжтэй хүргэх, зөвшөөрөлгүйгээр арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг олж илрүүлэн хариуцлага хүлээлгэх, ийнхүү хууль бус үйлдлийг таслан зогсоох чиглэлээр холбогдох хууль хяналтын байгууллага, татварын байгууллага, засаг, захиргааны нэгжүүдтэй харилцан мэдээлэл солилцон, шаардлагатай арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Ямар ч байсан бидний зүгээс энэ арга хэмжээг 2023 оныг дуусгавар болтол үе шаттайгаар хэрэгжүүлэх болно, бодитой үр дүн гарна гэсэн өндөр хүлээлттэй байгаа.






Ярилцлага энэ хүрээд өндөрлөж байна. Баярлалаа.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН НОГООН БҮТЭЭГДЭХҮҮН

Сайн байна уу, уншигч та бүхэнд тогтвортой санхүүжилт булангийнхаа энэ удаагийн дугаарт Дэлхийн банкны зөвлөхийн боловсруулсан Монгол Улсад ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх тухай судалгааны хөрөнгийн зах зээлд хөгжүүлж болох бүтээгдэхүүнүүдийн талаар танилцуулахаар бэлтгэлээ.

Хөрөнгийн зах зээлийн дараах төрлийн ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүнүүдээр дамжуулан байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт татдаг байна. Үүнд:

-  Ногоон бонд
-  Үнэт цаасжуулалт
-  Зээлийн тэлэлт /credit enhancement/
-  Ногоон хувьцааны санхүүжилт
-  Ногоон мортгэйжээр баталгаажсан үнэт цаас

Ногоон бонд: Ногоон бондын шинж чанар болон төлбөрийн хэлбэрийн ялгаатай 4 төрөл байдаг. Үүнд:

Ногоон бондын төрөл	Шинж чанар	Төлбөрийн хэлбэр
Стандарт ногоон бонд		Төлбөрийн буцаан олголт төслийн мөнгөн урсгалаас хамаардаггүй.
Ногоон орлогын бонд		
Ногоон төслийн бонд		
Үнэт цаасжуулсан ногоон бонд		

Азийн хөгжлийн банкны 2021 оны судалгаагаар банкнууд ногоон бондыг ихэвчлэн аж ахуй нэгж, иргэдийн ногоон төсөлд зээл олгох зориулалтаар гаргасан байдаг.

Ногоон бонд гаргахад Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооноос гаргасан “Ногоон бондын зарчмууд”-ыг мөрдөх ба уг бондын энгийн бондоос ялгарах зүйл нь ил тод байдлыг сайтар хангаж, хөрөнгө оруулагчийн итгэх итгэлийг хадгалах шаардлагатай.

Ногоон бондоор хөрөнгө оруулалт татах 4 алхам байдаг. Үүнд:






Хэрэглээ

Ногоон бонд гаргагчийн хувьд үнэт цаасны хууль ёсны шаардлагыг хангасан байх ба байгаль орчинд үзүүлэх өгөөжийг үнэлсэн байх хэрэгтэй. Олон улсад өнөөдрийн байдлаар сэргээгдэх эрчим хүч, байгалийн нөөцийн тогтвортой удирдлага, тогтвортой усны удирдлага, энергийн үр өгөөж, ногоон барилга, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бохирдлоос сэргийлэх, хянах, цэвэр тээвэрлэлт, мөчлөгийн эдийн засагт дасан зохицсон бүтээгдэхүүний чиглэлээр ногоон бондоор санхүүжилт татаж байна.

Төслийн үнэлгээ, сонголт

Ногоон бонд гаргагч нь хөрөнгө оруулагчидтай дараах чиглэлүүдээр харилцаатай байх:

-  Ногоон төслийн байгаль орчинд ээлтэй байх зорилго;
-  Бонд гаргагч хэрхэн байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулах процесс;
-  Төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгэмд үзүүлж буй эрсдэлийг удирдах дэлгэрэнгүй мэдээлэл.

Удирдлага

Ногоон бондоос татсан хөрөнгө оруулалт ногоон төслүүдэд хуваарилсан дүнтэй тэнцэж байх шаардлагатай ба төслийн хугацааны туршид үүнийг удирдана.

Тайлагнал

Ногоон бонд гаргагч нь үнэт цаасны хугацааны туршид төслийн талаар жил бүр мэдээллийг тайлагнадаг. Жилийн тайландаа ногоон бондоос татсан хөрөнгө оруулалтаар хийсэн төслүүдийн жагсаалт, товч танилцуулга, оруулсан хөрөнгө оруулалт болон хүлээгдэж буй үр дүнгийн талаар тусгана.

Түүнчлэн тайланд гүйцэтгэлийн чанарын болон тоон үзүүлэлт, аргачлалын тайлбарыг оруулахыг санал болгодог.



ФИНТЕК БА РЕГТЕК

РЭГТЕК БА ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэнд рэгтек болон түүний өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл хүргэхээр бэлтгэлээ. Финтекийн салбарын нэг хэлбэр болох Рэгтек нь санхүүгийн салбарын зохицуулалт, нийцлийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн технологи бөгөөд "зохицуулалт" болон "технологи" гэсэн утгыг илэрхийлдэг. Рэгтек нь дүрэм журмыг дагаж мөрдөх, тайлагнахад технологи ашиглах боломж ба зохицуулагч байгууллага болон компаниуд өөрсдийн эрсдэлийг илүү сайн удирдахад нь тусалдаг.

Рэгтекийг ашигласнаар дараах давуу талуудыг бий болгодог.

- Санхүүгийн салбарт бүтээгдэхүүн, үйлчилгээг хялбаршуулах, дижиталчлах;
- Байгууллагууд хууль, эрх зүйн хүрээнд хурдан зохицож ажиллах;
- Комплайнсын өртгийг бууруулах;
- Комплайнсгүй байх үеийн эрсдэлийг бууруулах;
- Бодит цагийн хамгаалалт;
- Эх үүсвэрийн хэрэглээг дээд түвшинд ашиглах;
- Хянан шалгагчийн цагийг хэмнэх, зардлыг бууруулах;
- Хяналтын алдааг бууруулах;

Санхүүгийн салбарт рэгтекийн шийдлүүд нь мөнгө угаахтай тэмцэх, хэрэглэгчийг таних, кибер аюулгүй байдлаас хамгаалах, тайлангийн өгөгдөлд шинжилгээ хийх, эрсдэлийг удирдах, залилангаас урьдчилан сэргийлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр хөгжиж байна. Хэрэглэгчдийн хувьд санхүүгийн зохицуулалтын дүрэм, журмыг ойлгож үйл ажиллагаагаа тэдгээрт нийцүүлэн явуулах, тайлан, мэдээллээ сайжруулах, стандартчилах, арилжаа, гүйлгээний мэдээллээ хянах, болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлох боломжийг рэгтек олгож байгаа юм.

Улс орнуудын санхүүгийн зохицуулагч байгууллагууд дүрэм журмын хэрэгжилт, мэдээлэл цуглуулах, салбарын тогтвортой байдал, зах зээлд оролцогчдын ил тод байдал, компанийн засаглал зэрэгт рэгтекийн шийдлүүдийг ашиглан хяналт тавих боломжтойгоос гадна өөрсдийн гүйцэтгэл, зохицуулалтын механизмыг ч мөн технологи

ашиглан хэрэгжүүлэх боломж бүрдсэн.

Регтекийг улс орон болон байгууллагууд ашигласнаар бодит цагийн горимоор хянах, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, нэг хянан шалгагчид ирэх ачааллыг бууруулах, үүлэн тооцооллыг ашиглан илүү өргөн хүрээний дата өгөгдөл дээр нарийвчилсан дүн шинжилгээ хийх, хяналт шалгалтын цар хүрээг нэмэгдүүлэх зэрэг зардал, цаг хугацааг хэмнэсэн олон давуу талыг бий болгон зохицуулалтын асуудлыг шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

РЭГТЕКИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ, БАЙДАЛ

Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын сүлжээ байгууллага болох KPMG-ээс гаргадаг "Pulse of Fintech" финтекийн салбарын тойм 2023 оны 1 дүгээр сард нийтлэгдсэн бөгөөд үүнд рэгтекийн талаар холбогдох тоон үзүүлэлтүүдийг дараах байдлаар тусгажээ.

2022 онд финтекийн ихэнх төрлүүдийн хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан үзүүлэлттэй байсан бол харин рэгтекийн хувьд өмнөх жилүүдээс огцом өсөж 18.6 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг татсан байна. Энэ нь 2022 оны сүүлийн хагас жилд АНУ-д хэд хэдэн томоохон худалдан авалт хийгдсэн нь ийнхүү өсөлттэй гарахад нөлөөлжээ. Үүнд Vista Equity Partners компани нь татварын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг рэгтекийн компани болох Avalara-г 8.4 тэрбум ам.доллаароор худалдаж авсан ба санхүүгийн рэгтекийн компани болох Computer Services Inc нь 1.6 ам.доллаароор Centerbridge Partners болон Bridgeport Partners-ийг тус тус худалдан авсан байна.


2022 онд дэлхий дахинд геополитикийн тодорхойгүй байдал, макро эдийн засгийн хүндрэлүүд байсан боловч рэгтекийн салбарын хөрөнгө оруулалт нь маш өндөр өсөлтийг харуулсан. Энэхүү нөхцөл байдал нь рэгтек санхүүгийн байгууллагуудад хууль тогтоомж, дүрэм, журмыг дагаж мөрдөх, тайлагнах үүргээ удирдахад нь чухал ач холбогдолтой болохыг илэрхийлсэн. Байгууллагуудын хувьд жил тутам санхүүгийн үйл ажиллагаа, гүйлгээний тоо нэмэгдсээр байгаа тул компаниуд болон хөрөнгө оруулагчид рэгтекийг хэрэглээг өсгөсөөр байна.

Зохицуулалтыг хэрэгжүүлэх зардлыг бууруулж байгаа нь рэгтекийг сонирхогчдын тоог нэмэгдүүлж байна

Байгууллагуудын хувьд комплайнсын зардал байнга өсөн нэмэгдэж байгаа нь дэлхийн өнцөг булан бүрд үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн үйлчилгээний компаниудад томоохон сорилт болж байгаа бөгөөд үндэстэн дамнасан компаниуд олон улс орнуудын хууль, эрх зүйн хүрээнд зохицон үйл ажиллагаагаа явуулахад ихээхэн бэрхшээлийг бий болгож байна. Дэлхийн улс орнуудын зохицуулалт,

хууль, журмууд байнга өөрчлөгдөж байгаа тул түүнтэй цаг алдалгүй зохицож ажиллах хэрэгцээ, шаардлагын улмаас рэгтекийн хөрөнгө оруулалт 2022 онд дөрөв дэх жилдээ дараалан өссөн гэж үзжээ. Учир нь хөрөнгө оруулагчид болон корпорацууд илүү хялбар, хэмнэлттэй, тогтвортой шийдлүүдийг хэрэгжүүлж, бодит цагийн горимоор ажиллаж чадах рэгтекийг хүлээн зөвшөөрч байгаатай холбоотой юм.

Зураг. Дэлхийн рэгтекийн салбарын 2022 оны хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: KPMG

2023 оны рэгтекийн салбарын чиг, хандлага, хөгжүүлэлт

- Сүүлийн хэдэн жилийн хугацаанд өөр өөр улс орнуудын зохицуулалтын хүрээнд дижитал банк, төлбөр тооцоо, крипто валютын гүйлгээг үнэн зөв, ил тод, найдвартай, нийцтэй байлгахад чиглэсэн рэгтек нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна.
- Мөнгө угаахтай тэмцэх шийдлүүдийг сайжруулах зорилгоор хиймэл оюун ухаан болон машин сургалтын технологийг рэгтект ашиглахад анхаарал хандуулж байна
- Нэг цэгийн үйлчилгээний рэгтек шийдлүүдийг түлхүү хөгжүүлж байна
- Зохицуулагчид Сингапурын төв банкны санхүүгийн эрсдэлийн талаарх ойлголтыг бий болгох хиймэл оюун ухаанд суурилсан техникийн платформд чиглэсэн NovA болон Хонг Конгийн төв банкны AMLab зэрэг хөтөлбөрүүдээр дамжуулан рэгтекийн хөгжлийг дэмжсээр байна.

СУДЛААЧИЙН ИНДЭР

НЭЭЛТТЭЙ БАНКНУУДАД ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ЗҮГЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАРИМТЛАХ БОДЛОГО, ТУРШЛАГА

/ХУРААНГУЙЛСАН/

Гүйцэтгэсэн:

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

*Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн Б.Батцэцэг
Battsetseg_b@frc.mn*

ХУРААНГУЙ

Монгол Улсын банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкнуудыг нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэхээр хуульчилсан бөгөөд банкны системийн нөлөө бүхий 5 банкиг заавал нийтэд нээлттэй хувьцаат компани байхаар тусгасан. Үүнтэй холбогдуулан энэхүү судалгаагаар Монгол Улсын банкны салбарын өнөөгийн байдал, банк олон нийтэд хувьцаагаа санал болгох (IPO)–д хууль, эрх зүйн зохицуулалт, нээлттэй хувьцаат компани болсноор гарах давуу тал, мөн түүнчлэн олон улс дахь банкны салбарын IPO, зохицуулалтын орчны талаар судаллаа.

Олон улсын хувьцааны зах зээлийн төвлөрлийг тодорхойлон 2000–2020 онд банкны салбарт гарсан нийт 305 IPO–г харьцуулж дүн шинжилгээ хийх, улс орнуудын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын талаар мэдээлэл цуглуулах, боловсруулах аргаар тус судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны үр дүнгээс харахад хөгжингүй орнуудаас илүү хөгжиж буй улс орны зах зээл дээр банк, зээлийн байгууллагууд IPO гаргаж хөрөнгө босгох өндөр боломжтой, ирээдүйтэй байна. Зөвхөн банк гэлтгүй аливаа компани нээлттэй компани болоход манай улсын холбогдох хууль тогтоомж, эрх зүйн орчин олон улсын жишигт хүрч, боловсронгуй болсон. Улмаар нээлттэй компаниудын тоо нэмэгдсээр байгаа тул мэргэжлийн оролцогч талуудын санхүүгийн боловсролыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

УДИРТГАЛ

Монголын хөрөнгийн зах зээл дээр 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 320 гаруй компани бүртгэгдэж, 170 гаруй компани хаалттай болон нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны эхний хагас жилд 4,841.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар өссөн нь Монголын хөрөнгийн зах зээлийн цар хүрээ эрчимтэйгээр тэлсээр байгааг харуулж байна. Уг өсөлтийг хэвээр хадгалах, банк, санхүүгийн салбарын хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах, ил тод, нээлттэй үйл ажиллагаа явуулах, сайн засаглалыг бүрдүүлэх зорилгоор 2021 онд Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан банкны системд нөлөө бүхий банк буюу сүүлийн 6 сарын турш банкны системийн нийт активын 5.0 хувиас дээш хувийг эзэлж байгаа 5 банкиг нээлттэй хувьцаат компани болгохоор хуульчилсан.

Банкны салбар улс орны эдийн засагт чухал байр суурь эзэлдэг бөгөөд эдийн засгийн тогтвортой байдал, эдийн засгийн хөгжил банкны салбараас ихээхэн хамаардаг. Банкны салбар нь эдийн засгийн өдөр тутмын үйл ажиллагааны үндэс суурь болдог учир хэрвээ банкны салбар хямралд орвол макро эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлж, эдийн засгийн хямралыг дагуулдаг.

Монгол Улсын санхүүгийн салбарын 83 орчим хувийг банкны салбар, 17 орчим хувийг банкнаас бусад санхүүгийн салбар эзэлдэг.

Тиймээс Банкны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу банк IPO гаргах нь банкнаас хэт их хамааралтай санхүүгийн зах зээлийг задалж, хөрөнгийн биржийг

хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Үүнээс гадна банк IPO хийх нь зөвхөн дотоодын гэлтгүй гадны хөрөнгө оруулагчдад ч банкныг нээлттэй болгож, гаднаас хөрөнгө татах, валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, олон улсын зах зээл дээрх Монгол Улсын нэр хүндийг өсгөх, дотоодын бизнесийн стандартыг сайжруулах, дэлхийн сайн жишгийг нутагшуулах зэрэг олон ач холбогдолтой.


Энэхүү судалгааны хоёрдугаар бүлэгт Монгол Улсын

банкнууд IPO гаргахад хууль эрх зүйн орчны талаар судлах бол гуравдугаар бүлэгт олон улс дахь банкны салбарын IPO-ны талаар, цаашлаад БНХАУ болон Мальта улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын талаар өгүүлнэ. Эцэст нь судалгаанд суурилсан санал, дүгнэлтийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛС БОЛОН ОЛОН УЛС ДАХ БАНКНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжин 30 жил орчим үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Дэлхийн банкнаас гаргасан 2020 оны Монголын эдийн засгийн тоймд Монгол Улсын санхүүгийн зах зээлийн 90 орчим хувийг банкны салбар эзэлдэг гэж дурджээ.

Зураг. Банкны салбар, оноор



Эх сурвалж: Банк тус бүрийн вэбсайт

2022 оны 5 сарын 31-ний өдрийн байдлаар банкны систем нийт 1,385 салбар нэгж бүхий 11 арилжааны банкнаас бүрдэж байна.

Монгол Улсын арилжааны банкуудад хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл буюу 3 хүртэлх тооны хувьцаа эзэмшигч 90-ээс дээш хувийг эзэмшсээр ирсэн. 2021 оны 1 дүгээр улиралд банкны салбарын нийт активын хэмжээ 37.2 их наяд төгрөг байсан бөгөөд үүний 90 орчим хувийг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө, үлдсэн 10 гаруй хувийг банкны эздийн өмч бүрдүүлж

байсан. Энэхүү хэт төвлөрөл нь санхүүгийн салбарын хөгжил, тогтвортой байдал, эрсдэлд сөргөөр нөлөөлөх тул уг салбарын засаглалыг ахиулж, илүү ил тод, нээлттэй болгох нь зүйтэй гэж үзэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн УИХ-ын намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. “Банкны тухай хууль”-д дараах дөрвөн үндсэн зарчмыг баримтлан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

1. **Банкийг нээлттэй болгох.** Банкны системийн хэмжээнд нийт 12 банк үйл ажиллагаа явуулж байгаагаас системд нөлөө бүхий таван банк хуулийн зохицуулалтын дагуу 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болж, санхүүгийн зах зээлд IPO гаргасан байх үүрэгтэй болно. Харин бусад банкнуудад нээлттэй эсхүл хаалттай хувьцаат компани байх сонголтыг нээлттэй үлдээв.
2. **Хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах.** Нэг хувьцаа эзэмшигч дангаараа болон холбогдох этгээдийнхээ хамт тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй хэмжээний хувийг эзэмшихээр тусгаж өгсөн. Хуулийн энэхүү шаардлагыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүх банк хангах үүрэгтэй.
3. **Банк татан буугдсан үед төлбөр барагдуулах дарааллыг ойлгомжтой болгох,** хуримтлалтай иргэн, өрхийн хууль ёсны эрхийг хамгаалахад чиглэсэн байдлаар оновчтой байлгах зохицуулалтыг хуульд тусгав. Энэ хүрээнд иргэд тэргүүн ээлжид хадгаламж болон харилцах дансанд байгаа өөрийн мөнгөн хөрөнгийг хуулийн этгээдийн өмнө буюу тэдгээрээс тэргүүн ээлжид авна.
4. **Банкны систем дэх нөлөө бүхий банкны тодорхойлолтыг нарийвчлан боловсронгуй болгох.** Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд зааснаар нийт системийн таваас дээш хувийг эзэлж байгаа бол системийн нөлөө бүхий банк гэж тодорхойлсон. Харин энэ зохицуулалтаар зөвхөн зах зээлд эзлэх хувиар бус банкны хөрөнгө, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал, мөн харилцагчдын тоо бусад хүчин зүйлсийг авч үзэхээр тусгасан.

Хуулийн хэрэгжилтийн дагуу банкнууд нээлттэй компани болох хугацааг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тогтоож, системийн нөлөө бүхий 5 банк бүх хувьцаагаа бус 5-15 хувийн хувьцаагаа олон нийтэд хүргэхээр хуульчилсан. Монгол Улсын банкны системийн нийт активын хэмжээ 38-40 их наяд төгрөгийн хооронд байгаа нь улсын дотоодын нийт бүтээгдэхүүнтэй тэнцүү байгаа юм. Харин банкнуудын өөрийн хөрөнгө 4.0 их наяд төгрөг байгаагаас харахад 500-700 орчим тэрбум төгрөгийн хувьцааг олон нийтэд санал болгохоор тооцоолж байна.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор хувьцаа

эзэмшлийн төвлөрөл буурч, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх ач холбогдолтой. Түүнчлэн арилжааны банкнуудад хувьцаа эзэмшил, удирдлагын төвлөрсөн байдлаас үүдэлтэй эрсдэл буурч, банкны хувьцааны эзэмшил, мэдээллийн хүртээмжээр дамжуулан олон нийтийн хяналт бий болох, зах зээлийн дохиолол бүрдэх, банкны хяналт шалгалтын бие даасан байдал нэмэгдэхээс гадна хөрөнгийн зах зээлийн хөгжилд эергээр нөлөөлөх олон давуу талтай.

Банк нээлттэй компани болох, санхүүгийн зах зээлд IPO гаргахыг дараах хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна:

- ◆ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013);
- ◆ Компанийн тухай хууль (2011);
- ◆ Банкны тухай хууль (2021);
- ◆ Үнэт цаасны бүртгэлийн журам (2021);
- ◆ Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам (2021)
- ◆ Бусад холбогдох дүрэм, журам.

Түүнчлэн харилцагч нар зөвхөн банканд мөнгөө хадгалуулах бус хөрөнгийн биржээр дамжуулан тухайн аж ахуйн нэгжийн хувьцааг авснаар өөрийн санхүүг төлөвлөх, санхүүгийн салбарын мэдлэг, мэдээлэл нэмэгдэх, ногдол ашиг болон бусад үр шимийг хүртэх бүрэн боломжтой болно.

Холбогдох хууль тогтоомжид системийн нөлөө бүхий банкнууд 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр гэхэд нээлттэй хувьцаат компани болсон байх, бусад банкнуудын хувьд нээлттэй эсхүл хаалттай хувьцаат компани байх сонголтыг нээлттэй үлдээсэн. Хэдийгээр нээлттэй хувьцаат компани болох үүргийг хуулиар хүлээгээгүй ч “Богд банк” Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн хүрээнд анх удаа хувьцаагаа олон нийтэд нээлттэй гаргаж хувьцаат компани болж банкны салбарын шинэчлэл эхэлсэн. Тодруулбал, Богд банк анх 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах

зээл дээр хувьцаагаа арилжсан. Нийт 12.5 сая ширхэг хувьцаа гаргаж, нэгж хувьцааг 2,540.00 төгрөгөөр борлуулж, нийт 31.75 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн.

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд “Голомт” болон ХААН банк хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргахад бэлэн гэдгээ илэрхийлж, Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлтээ ирүүлээд байна.


Гэвч Эдийн засгийн байнгын хорооноос системийн нөлөө бүхий банкнууд 2022 оны 6 сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болох гэсэн хугацааг сунгах санал гаргасан. Засгийн газар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос ирүүлсэн санал, Олон улсын валютын сангийн зөвлөмжийг дэмжиж, цар тахал болон олон улсын хямралт байдлын энэ цаг үед банкнууд нээлттэй компани болох хугацааг түр хойшлуулах нь зүйтэй гэж үзсэн.

ОЛОН УЛС ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН IPO

Дэлхийн санхүүгийн түүхэнд хамгийн анхны IPO 1602 онд Амстердамын хөрөнгийн бирж дээр “The Dutch East India” компани хөрөнгө босгох зорилгоор компанийн хувьцаа болон бондыг олон нийтэд санал болгосноор бий болж байсан.

2000–2020 онд банкны салбарт 305 IPO гарч, нийт 218.0 тэрбум ам.долларын санхүүжилт татаж байсан. Дараах графикаас харахад 2005–2007, 2010–2011, 2014–2017 гэсэн гурван давлагаа ажиглагдаж байгаа бөгөөд энэ үед зөвхөн банкны салбарын IPO өссөн биш нийт хөрөнгийн зах зээл дээр гарч байсан үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн идэвхжилтэй холбоотой юм. Банкнуудын 20 жилийн хугацаанд хийсэн IPO-ийн дундаж хэмжээ 711.0 сая ам.доллар байсан ба нийт арилжааны дундаж хэмжээ өндөр хөгжилтэй улс орны зах зээл дээр 309.0 сая ам.доллар, хөгжингүй орны зах зээл дээр 1,100.0 сая ам.доллар байгаа нь хөгжиж буй улс оронд арилжааны түвшин илүү өндөр байгааг харуулж байна.


Зураг. Банкны салбар дахь IPO хэмжээ ба эхний өдрийн дундаж өгөөж



Эх сурвалж: CapitalIQ, PREQVECA, 2021

Түүнчлэн хөгжиж буй улс орны зах зээл дээр өндөр дүнтэй хэлцэл буюу 1.0 тэрбум доллароос дээш дүнтэй хэлцэл, арилжааны эхний өдрийн дундаж ашиг тус тус хөгжингүй улс орнуудаас өндөр байсан.


Зураг. Банкны IPO тоо



Эх сурвалж: CapitalIQ, PREQVECA, 2021


2000–2020 онд банкны IPO гарган татан төвлөрүүлсэн санхүүжилтийн хэмжээг газарзүйн байрлалын хувьд авч үзвэл 49.0 хувийг БНХАУ, удаах 15.0 хувийг Европын холбооны улсууд эзэлж байна.

Зураг. 2000–2020 онд банкны IPO-ийн эзлэх хувь, улс орноор



Эх сурвалж: www.Capitaliq.com, 2021

Зураг. 2000–2020 онд гаргасан банкны IPO тоо, улс орноор




Эх сурвалж: www.Capitaliq.com, 2021

Хятадын эдийн засаг өндөр өсөлттэй байгаа бөгөөд банкнууд санхүүгийн зах зээлд хувьцаагаа байршуулах замаар санхүүгийн эх үүсвэр үүсгэсээр байна. Хятад улс зөвхөн банкны IPO төдийгүй нийт IPO-ийн зах зээлд амжилт тогтоосон арилжааг хийж байсан. Тухайлбал, 2022 оны 6 сарын байдлаар олон улсад IPO гаргаж хамгийн өндөр дүнтэй санхүүжилт татан төвлөрүүлсэн шилдэг 20 компанийн жагсаалтад Хятадын 2 банк багтсан.

Энэхүү жагсаалтын 10 дугаарт Шанхайн хөрөнгийн бирж болон Хонг Конгын хөрөнгийн биржид бүртгэлтэй БНХАУ-ын Аж үйлдвэр, худалдааны банк (ICBC) 2006 онд IPO гаргаж 13.96 тэрбум ам.долларын санхүүжилт татан төвлөрүүлснээр, Хөдөө аж ахуйн банк нь 2010 онд IPO гаргаж 10.42 тэрбум ам.доллар татан төвлөрүүлснээр тус жагсаалтын 18 дугаарт жагссан байна.

Хятад улс 2002 онд Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орсны дараа Хятадын Засгийн газар банкны салбарыг либералчлах чиглэлийг тодорхойлсон. Төрийн банкны бодлого банкнуудын ашиг орлого олох, чанаргүй зээлийг бууруулахад чиглэсэн. Банкнуудын хугацаа хэтэрсэн зээлийн хувь өндөр байсан бөгөөд зээлийн хэмжээ нь нийт активын 11–15 хувьд хүрч байсан. Иймээс банкнууд үнэт цаас гаргах замаар хөрөнгө татсан нь санхүүгийн тогтвортой байдал, ил тод байдлыг нэмэгдүүлсэн шинэ ажил болсон.


Зураг. Хятад улсын банкны IPO хэмжээ, бусад улс оронтой харьцуулснаар



Эх сурвалж: www.Capitaliq.com, 2021

IPO хийсэн тоогоор АНУ нэгдүгээрт бичигддэг ч нийт босгосон хөрөнгийн хэмжээгээрээ АНУ Хятад улсын дараа ордог. АНУ-ын IPO хэлцлийн дундаж 153.0 сая ам.доллар, дундаж үнэ нь 55.0 сая ам.доллар байгаа нь дэлхийн дунджаас 3 дахин бага байна. Гэсэн хэдий ч АНУ-ын банкны IPO зах зээлийн төлөв байдлаас үл хамааран тогтвортой гардаг нь сонирхолтой үзүүлэлт юм. АНУ-ын хоёрхон банк IPO хийхдээ 1 тэрбум гаруй ам.доллар босгосон нь CIT Group 2002 онд 4,600 сая ам.долларын хувьцаа арилжиж байсан бол Eastern Bankshares 2020 онд 1,792.0 сая ам.долларын санхүүжилт босгожээ.

Зураг. АНУ-ын банкны IPO хэмжээ, сая.доллароор



Эх сурвалж: www.Capitaliq.com, 2021

ДУГНЭЛТ, САНАЛ

Банк олон нийтэд хувьцаагаа арилжаалснаар нэг эзний бус, олон нийтийн хараа хяналтад орно. Энэ нь банкны засаглалыг сайжруулахаас гадна тухайн банкны үнэ цэн бирж дээр арилжаалагдаж байгаа хувьцааны үнээр тогтдог болно. Өөрөөр хэлбэл, банк өөрөө өөрийгөө “сайн банк, том банк” гэж үнэлэх бус, энэ үнэлгээг олон улсын жишгээр зах зээл, зах зээл дээрх хувьцааны ханшийн хөдөлгөөн тодорхойлох юм.

Хууль эрх зүй, зохицуулалтын хувьд олон улсад тусгайлан банк IPO гаргахад зориулсан зохицуулалт гэж байдаггүй. Өөрөөр хэлбэл, зөвхөн банк гэлтгүй ямар ч компани нээлттэй компани болон олон нийтэд хувьцаагаа санал болгоход Үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль зэрэг хууль тогтоомжийн хүрээнд ижил зохицуулагдана. Манай улсын хувьд хууль эрх зүйн орчин, хууль тогтоомж, дүрэм, журам олон улсын шаардлага, жишигт нийцсэн.

Банк хувьцаа гаргахад хувьцааны үнийг тогтооход хүндрэл тулгардаг учир нь банкны зээлтэй шууд холбогддог. Зээл хэр чанартай, чанаргүйгээс шалтгаалж тухайн банкны ашигт

ажиллагаа 180 градус эргэх боломжтой. Мөн банкны салбар нь эдийн засагт маш том орон зайг эзэлдэг тул хувьцааны үнэ савлах, хөрөнгө оруулагчдын эрх ашиг алдагдах тохиолдолд эдийн засагт савлагаа үүсэж, тогтворгүй байдал үүсэж болно.

Иймээс зохицуулагч байгууллага, төв банкны зүгээс үнийн зохицуулалт, эргэн тайлагнал, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зэрэг өөр өөрийн чиг үүргийн дагуу буюу Банкны тухай хууль, Компанийн тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт, шалгалтыг хийнэ. Шаардлагатай тохиолдолд хамтарсан хяналт шалгалтыг хийх замаар зохицуулна. Тодруулбал, банк олон нийтэд нээлттэй компани болоход Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны хяналт шалгалтын хүрээг дараах хүснэгтэд харууллаа.

Санхүүгийн зохицуулах хороо	Монголбанк
Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан чиг үүрэг	Санхүү, төлбөрийн чадвар, эрсдэлийн үнэлгээ
Компанийн тухай хуулийн холбогдох заалтуудын хүрээнд	Активын чанарын үнэлгээ
Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах	Төлбөр тооцоо, зээлийн чиглэлээр
Ногдол ашгийн хуваарилалт, нөхцөл	Тайлан, мэдээллийн шинжилгээ
Холбогдох хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтийг хангуулах	Холбогдох хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтийг хангуулах

Судалгааны үндсэн дээр дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- ◆ Зах зээлийн болон хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд арилжааны шимтгэлийг бууруулах;
- ◆ KPMG-ийн судалгаагаар судалгаанд хамрагдсан жижиг хувьцаа эзэмшигчдийн 64.4 хувь нь банкны IPO талаар болон хэрхэн оролцох талаар мэдлэг, мэдээлэл дутмаг гэж гарсан тул IPO хийхээр төлөвлөж буй банкууд олон нийтэд мэдээллээ сайн түгээх;

- ◆ Олон улсын чиг хандлагын дагуу хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор IPO-оос олсон орлогод ногдуулах татварыг бууруулах;
- ◆ Банкны IPO-г олон улсын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх;
- ◆ Зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, зах зээлийг хянах хяналтыг сайжруулах. Үүнтэй холбоотойгоор зохицуулагч байгууллага хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх;
- ◆ Үнэт цаасны танилцуулга, бусад мэдээллийг англи хэл дээр гаргах, түгээх, ингэснээр гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг татах боломжтой болно.

ТАВ. ЭХ СУРВАЛЖ

- ◆ Analysis of the dynamics of IPO transaction in banking sector, V.A.Belyaev, 2021
- ◆ Beckmann, Joscha, Klaus-Jürgen Gern, and Nils Jannsen. "Should they stay or should they go? Negative interest rate policies under review." *International Economics and Economic Policy* (2022): 1–28. <https://www.ecb.europa.eu/pub/pdf/scpwps/ecb.wp2199.en.pdf>
- ◆ Central bank of Oman, Financial stability. <https://cbo.gov.om/Pages/RegulatoryFramework.aspx>
- ◆ IPO activity and market volatility, Dicle.M, Levendis J. *Journal of entrepreneurship and public policy*, 2018
- ◆ Equity capital markets in China: Regulatory overview
- ◆ [https://uk.practicallaw.thomsonreuters.com/3-532-3588?transitionType=Default&contextData=\(sc.Default\)](https://uk.practicallaw.thomsonreuters.com/3-532-3588?transitionType=Default&contextData=(sc.Default))
- ◆ Equity capital markets in Malta: Regulatory overview
- ◆ [https://uk.practicallaw.thomsonreuters.com/4-617-4799?transitionType=Default&contextData=\(sc.Default\)](https://uk.practicallaw.thomsonreuters.com/4-617-4799?transitionType=Default&contextData=(sc.Default))

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

... Үргэлжэл

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчлөгчийн хувьд төрийн зүгээс компаниудын үйл ажиллагааны нэгдсэн тайланг жил бүр цахим хэлбэрээр олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар хүргэхийн зэрэгцээ, нэгдсэн тайланд хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хүрээнд гаргах шаардлагатай мэдээллээс гадна санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд, компанийн үнэ цэнийг өсгөхтэй холбоотой нэмэлт мэдээллийг агуулах ёстой.

Дээр дурдсан жилийн үйл ажиллагааны нэгдсэн тайланд тухайн хуулийн этгээдэд хэрэгжүүлж буй төрийн өмчлөлийн бодлого, түүний хэрэгжилт, төрийн өмчийн багцын үнэ цэнэ, төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүрэлдэхүүнд гарсан өөрчлөлт, санхүүгийн гол үзүүлэлтүүд, харьцаанууд, мэдээллийн өгөгдлийг нэгтгэхэд ашигласан арга, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлууд, ТУЗ-ийн гишүүдийн оролцоо, тэдгээрийн ашиг сонирхлын байдал, цалин урамшууллын хэмжээ, шалгуур үзүүлэлт, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх холбогдох мэдээллийг тусгах нь зүйтэй.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас гаргасан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ил тод, нээлттэй байдлын судалгаагаар нийт хамрагдсан 52 орны олонхонд нь жилийн үйл ажиллагааны нэгдсэн тайланг цахим хэлбэрээр нийтэлдэг байна. Эдгээр орнуудын хувьд ихэнх нь төрийн өмчлөлийн төвлөрсөн тогтолцоотой тул нэгдсэн тайлан гаргахад илүү хялбар байдгийг дурдах нь зүйтэй бөгөөд компаниуд санхүүгийн тайланг гаргаж хэвшсэн бол санхүүгийн бус үйл ажиллагааны талаарх мэдээллийг нийтлэх түвшин харьцангуй өөр өөр байна.

Азийн улс орнуудын хувьд ихэнх нь төрийн өмчлөлийн төвлөрсөн бус тогтолцоотой, асуудал эрхэлсэн голлох яамнууд компанийн хувьцааг эзэмшин төрийн төлөөллийг хэрэгжүүлж, бусад төрийн байгууллагууд зохицуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Судалгаанд хамрагдсан Энэтхэг, Филиппин, Тайланд зэрэг улсад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн үйл ажиллагааны нэгдсэн тайланг тогтмол гаргаж, олон нийтэд хүргэдэг. Тухайлбал, Энэтхэг улсын хувьд Төрийн өмчит байгууллагын газар нь санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг багтаасан иж бүрэн нэгдсэн тайланг парламентаараа жил бүр хэлэлцүүлдэг байна.

Филиппин улсын хувьд Төрийн өмчийн компанийн газар нь нэгдсэн тайлан гаргаж, Ерөнхийлөгч болон хууль тогтоох байгууллагад нээлттэй хэлбэрээр танилцуулдаг бол Тайланд улсад Төрийн компанийн газар нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны тайланг улирал бүр гаргадаг байна.

Харин Малайз, Пакистан, Вьетнам зэрэг улсын хувьд жилийн үйл ажиллагааны нэгдсэн тайланг гаргадаггүй буюу ТӨК-ийн талаарх мэдээллийг шаардлагатай үед тухай бүр гаргадаг ба энэхүү тайлан нь ихэнхдээ цаг хугацааны хувьд хоцрогдсон, мөн хэсэгчилсэн мэдээлэл агуулдаг тул асуудал хариуцсан яамдын үйл ажиллагаанаас хамаарч мэдээллийн чанар болон агуулга, цар хүрээ нь харьцангуй өөр өөр байдаг байна. Гэтэл чанар болон цар хүрээтэй мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр хүргэх нь ач холбогдолтой гэдгийг цохон дурдах нь зүйтэй.

БНСУ-ын хувьд нэгдсэн тайлан гаргадаггүй боловч Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд Төрийн мэдээллийн нэгдсэн системийг хэрэгжүүлдэг тул холбогдох

мэдээлэл олон нийтэд хүрдэг гэж үзэж болохоор. Тус төрийн мэдээллийн нэгдсэн системд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2005 оноос хойших үйл ажиллагааны мэдээллийг тусгаж ирсэн байна.

Казахстан улсын хувьд нэгдсэн тайлан гаргадаггүй боловч өмнөх дугаарт дурдаж байсан төрийн өмчит Самрук–Казына компани нь өөрийн тайландаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг оруулдаг байна.

ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны тайланд хамрагдсан Азийн ихэнх улс орнууд ТӨК–ийн хариуцлага, гүйцэтгэлийг сайжруулах хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлагад нийцүүлэх талаар ахиц дэвшил гаргасныг тэмдэглэх нь зүйтэй. Тэд гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцооны зарим хэлбэрийг бий болгосон хэдий ч засаглалтай холбоотой нийтлэг бэрхшээлүүд болох мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгох хууль эрх зүйн болон зохицуулалтын цогц тогтолцоо дутмаг байсаар байна.

ТӨК–ийн тайлагналын стандарт сайжирч байгаа хэдий ч судалгаанд хамрагдсан орнуудын тал хувьд нь нэгдсэн тайлан гаргах асуудал хоцрогдсон хэвээр байна. Мөн ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын бие даасан байдал нь нийтлэг сул тал гэж тооцогджээ.

Цаашид бодлого боловсруулагчид ТӨК–ийн хариуцлага, нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд дараах асуудалд анхаарах шаардлагатай талаар тус тайланд дурдсан байна. Үүнд:

Өмчлөлийн тогтолцоог төвлөрүүлэх

Олон улсад хэрэгжиж буй сайн туршлагаас харахад өмчлөлийн тогтолцоог төвлөрүүлэх нь ТӨК–ийн нэгдсэн тайланг гаргаж хэвшихэд чухал үүрэгтэй, хүчтэй хөдөлгөгч хүч болдог. Өмчлөлийн тогтолцоог төвлөрүүлэх нь ТӨК–ийн ТУЗ–ийг томилох, нэр дэвшүүлэх, санхүүгийн тайлан гаргах,

боловсон хүчний нөөц бүрдүүлэх чадавхыг бэхжүүлэх ихээхэн хувь нэмэртэй.

ТӨК–ийн санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагааны зорилтыг тодорхой болгох

Засгийн газар нь төрийн өмчийн зохицуулалтын нэгжээр дамжуулан асуудал хариуцсан яамд болон агентлагуудтай зөвшилцөн ТӨК–дын санхүүгийн болон санхүүгийн бус гүйцэтгэлийн зорилтуудыг тодорхойлж, дагаж мөрдөх шаардлагатай байдаг.

Нэгдсэн тайлан гаргах сайн туршлагыг нэвтрүүлэх

Засгийн газрын зүгээс бүх ТӨК–ийг хамарсан нэгдсэн тайланг жил бүр хэвлэн нийтлэх замаар санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын чанарыг сайжруулж болно. Олон улсын сайн туршлагаас үзэхэд олон нийтэд хүргэх мэдээллийг хүртээмжийг хөнгөвчлөхийн тулд цахим хэлбэрт суурилсан сувгийг хөгжүүлэх нь үр дүнтэй байна.

Иж бүрэн аудитын тогтолцоог бүрдүүлэх

ТӨК–ийн тайлагналын үнэн зөв байдал болон чанарт хяналт тавих, аливаа зөрчлийг ТУЗ–д мэдээлэх дотоод хяналтын тогтолцоо дутмаг байна. Зарим тохиолдолд ТӨК–ийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитад хийгддэггүй тул зөрчилтэй хэлцэл хийх нөхцлийг бүрдүүлдэг. Түүнчлэн, ТӨК–ид хийгдэж буй төрийн аудит, хөндлөнгийн аудитын үүрэг хариуцлагыг тодорхой заадаггүйгээс давхардал үүсдэгийг анхаарах нь зүйтэй.

ТУЗ–ийг мэргэшүүлэх

Тохиромжтой, ур чадвартай ТУЗ–ийн гишүүдийг сонгон шалгаруулах асуудлыг Засгийн газрын түвшинд авч үзэн, тусгайлан анхаарах шаардлагатай байдаг. ТУЗ–ийн гишүүнд нэр дэвшүүлэх болон сонгон шалгаруулалтын холбогдох мэдээлэл, санал хураалтын дүн зэргийг олон нийтэд нээлттэй, ил ил тод байлгах нь ТУЗ–ийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах ач холбогдолтой юм.

Эх сурвалж: www.adb.org



ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГЭЖ ЮУ ВЭ?



Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь ирээдүйд олох орлогоор хөрөнгийн багц бүрдүүлэн тусгай зориулалтын компани байгуулж олон нийтэд нээлттэй, хаалттай хүрээнд санал болгодог үнэт цаасжуулсан санхүүгийн хэрэгсэл юм.

Зээл, түрээсийн орлого, үүрэн телефоны дараа төлбөрт хэрэглэгчдийн төлбөрөөр
ХӨРӨНГИЙН БАГЦ бүрдүүлэх



Хөрөнгө оруулагчид ирээдүйд орох орлогыг эзэмших замаар
ӨГӨӨЖ ХҮРТЭХ

Хөрөнгийн багц–ирээдүйд олох орлогыг багцлан **ҮНЭТ ЦААС** гаргах

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

ТӨРӨЛ



Баталгаат үнэт цаас – зөвхөн тусгай зориулалтын компани гаргах




Барьцаат үнэт цаас – Банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани гаргах

ЭРСДЭЛ БА ӨГӨӨЖИЙН ТҮВШИН



ДАВУУ ТАЛ



Эрсдэл багатай



Хүссэн үедээ зарах боломжтой



Тогмол өгөөжтэй



Хөрөнгө оруулагчийн эрх ашиг хамгаалагдсан



Хөрвөх чадвар сайтай

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН, ДЭЛХИЙН БАНКНЫ 2023 ОНЫ ХАВРЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛЛОО.



ОУВС, Дэлхийн банкнаас жил бүр зохион байгуулдаг хаврын чуулга уулзалт 2023 оны 04 дүгээр сарын 10-наас 04 дүгээр сарын 16-ны хооронд АНУ-ын нийслэл Вашингтон ДС хотод болж өнгөрлөө. Энэхүү уулзалтад дэлхийн 189 орны төв банкны ерөнхийлөгч, сангийн сайд нар оролцож дэлхий нийтийн болон улс орнуудад тулгарч буй сорилт бэрхшээл, ирээдүйн төлөв, ядуурлыг арилгах, дэлхийн эдийн засгийн хөгжлийн талаар санал бодлоо солилцдог онцлогтой.

Энэ удаагийн уулзалтаар буурай хөгжилтэй орнуудад дэмжлэг үзүүлэх замаар ядуурлыг бууруулах, төсвийн бодлогыг төв банкны бодлоготой уялдуулах, геополитикийн зөрчилдөөнөөс үүдэлтэй худалдааны болон санхүүгийн хямралын даван туулах, цар тахлын нөлөөнөөс үүдэлтэй өрийн үлдэгдэлтэй улс орнуудыг дэмжих зэрэг асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэв.

www.worldbank.org

ИХ БРИТАНИЙН ИНФЛЯЦ БУУРСАН Ч ХОЁР ОРОНТОЙ ТООНД ХЭВЭЭР БАЙНА.

Их Британийн Үндэсний статистикийн газраас мэдээлснээр хэрэглээний үнийн индекс гуравдугаар сард өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хэрэглээний үнийн индекс 1-р сард 10.1 хувь, 2-р сард 10.4 хувиар өссөн бөгөөд хэрэглээний үнийн индекс өнгөрсөн оны аравдугаар сард 11.1 хувьд хүрсэн нь сүүлийн 40 жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн.



Их Британид өнгөрсөн оны дөрөвдүгээр сараас эхлэн хүнс, эрчим хүчний бүтээгдэхүүний үнэ огцом нэмэгдсэн нь инфляцыг өсгөхөд голлон нөлөөлсөн бөгөөд Английн төв банкнаас инфляцыг бууруулах зорилгоор энэ оны 3 дугаар сард бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр өсгөсөн нь 2021 оны арван хоёрдугаар сараас хойш 11 удаа дараалан өсгөсөн үзүүлэлт юм.

www.nytimes.com

АЗИЙН ТӨЛӨӨХ БОАГИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ 2023 (BFA) БОЛЛОО.



БНХАУ-ын Хайнань мужийн Боао хотод 2023 оны 3 дугаар сарын 28-наас 3 дугаар сарын 31-ны өдрүүдэд Азийн

чуулга уулзалт (BFA) 2023 болж өнгөрлөө. Энэ удаагийн хурлаар Азийн бүс нутгийн улс орнуудын хамтын ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлт, ногоон эрчим хүч, дижитал эдийн засаг зэрэг сэдвүүдээр Азийн бүс нутгийн төр засгийн удирдлага, бизнесийн төлөөлөл, эрдэмтэн судлаачдын хүрээнд санал солилцлоо.

www.boaforum.org

MOODY'S АГЕНТЛАГ: БНХАУ ХИЛЭЭ НЭЭСНЭЭР МУ-ЫН БАНКНЫ САЛБАРТ ЭЕРГЭЭР НӨЛӨӨЛНӨ.



Олон Улсын зээлжих зэрэглэл тогтоогч Мүүдис (Moody's) агентлаг “БНХАУ-ын эдийн засаг эрчимтэй сэргэж байгааг онцлон цар тахлын дараа Хятад улс хилээ нээснээр Ази номхон далайн бүс нутгийн орнуудад тэр дундаа Монгол улсын эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлж, зээлжих зэрэглэлийн “В3/ Тогтвортой” түвшинд байгаа Монгол улсын банкны салбарт хамгийн таатай нөлөө үзүүлнэ” гэж мэдэгдэв.

www.moody.com

ХОЛБООНЫ НӨӨЦИЙН БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ДАХИН ӨСГӨХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.

АНУ-д гуравдугаар сард хүнс, эрчим хүчний үнийг оруулаагүй суурь хэрэглээний үнийн индекс 2 дугаар сараас 0.4 хувиар өссөн нь инфляцын эрч саарч харьцангуй тогтворжиж байгааг харуулж байна. Өсөлт эрчим хүчний үнэ буурч, хүнсний үнэ тогтвортой байсантай холбоотой гэж үзжээ. Холбооны Нөөцийн банк өмнөх сард бодлогын хүүг 0.25 нэгж хувиар өсгөж 5 хувьд хүргээд байгаа ч энэ сард дахин 0.25 нэгжээр өсгөж 5.25 хувьд хүргэх төлөвтэй гэж шинжээчид таамаглаж байна.



www.bloomberg.com

АРГЕНТИН УЛСЫН ТӨВ БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ 81 ХУВЬ ХҮРТЭЛ НЭМЭГДҮҮЛЛЭЭ.



Аргентин улсын Төв банкнаас 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр инфляц гуравдугаар сард хүлээлтээс давж, инфляцын түвшин жилийн дүнгээр 104 хувьд хүрсэн тул, бодлогын хүүгээ хүлээгдэж байснаас 300 нэгжээр нэмэгдүүлэхээр шийдвэрлэснээ мэдэгдлээ.

Гуравдугаар сарын инфляцын түвшин 7.7 хувьд хүрч, сүүлийн хорин жилийн хамгийн өндөр үзүүлэлт болсны дараа Төв банкнаас бодлогын хүүгээ 78 хувиас 81 хувь хүртэл өсгөх шийдвэр гаргажээ.


www.reuters.com

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр

S&P 500 /[^]GSPC/


4,129.79 -24.73 (-0.60%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /[^]N225/


28,638.24 -19.33 (-0.07%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /[^]FTSE/


7,902.61 +3.84 (+0.05%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite ([^]IXIC)

12,059.56 -97.67 (-0.80%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia